



ХУЛГАЙЛСАН ЭСВЭЛ ХУУЛЬ БУСААР ЭКСПОРТОЛСОН СОЁЛЫН ЭД ЗҮЙЛСИЙН ТУХАЙ ЮНИДРУА-гийн КОНВЕНЦ

(Ром, 1995 оны 6 дугаар сарын 24)

Энэ конвенцид оролцогч улсууд,

Хулгайлсан эсвэл хууль бусаар экспортолсон соёлын эд зүйлсийн олон улсын буцаалтын тухай ЮНИДРУА-гийн Конвенцийн төсөл батлах Дипломат бага хуралд Бүгд Найрамдах Итали Улсын Засгийн газрын урилгаар 1995 оны 6 дугаар сарын 7-ноос 24-ний өдрүүдэд Ром хотноо цугларч,

Соёл иргэншлийн дэвшил, хүн төрөлхтний сайн сайхны төлөө соёлыг түгээх, ард түмэн хоорондын харилцан ойлголцлыг хөхиулэн дэмжихэд соёлын солилцоо болон соёлын өвийн хамгаалалт үндсэн ач холбогдолтойд итгээж,

Соёлын эд зүйлсийн хууль бус худалдаа ба түүнээс үүдсэн үр дагавраас болж, ялангуяа археологийн дурсгалт газруудыг тоносноос, бүх ард түмний өв хийгээд улс үндэстэн, овог, уугуул бусад бүл хамт олны соёлын өв болон эд зүйлст нөхөшгүй хохирол байнга учирч археологи, түүх, шинжлэх ухааны орлуулшгүй мэдээлэл алдагдаж буйд үнээс сэтгэл зовиурлааж,

Бүхний ашиг сонирхлын үүднээс соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг боловсронгуй болгох зорилт тавьж, хэлэлцэн тохирогч улсуудын хооронд соёлын эд зүйлсийг эгүүлэх болон буцаах нийтлэг, наад захын эрх зүйн хэм хэмжээг тогтоо чухал алхам хийн соёлын эд зүйлсийн хууль бус худалдаатай тэмцэх тэмцэлд үр дүнтэй хувь нэмэр оруулахаар сэтгэл шулууудаж,

Соёлын эд зүйлсийн эгүүлэг болон буцаалтад энэ конвенц дөхөм болох учиртай бөгөөд эгүүлэх болон буцаахад зарим улсад шаардагдах нөхөн төлбөр гэх зэрэг аливаа эрх зүйн хамгаалалтын хэрэглүүрийн талаарх заалтыг бусад улсад батлах албагүйг цохон тэмдэглэж,

Энэ конвенцийн заалтуудыг ирээдүйд хэрэгжүүлэхээр батлахдаа конвенц хүчин төгөлдөр болохоос өмнө үйлдсэн байж болох аливаа хууль бус хэлцлийг ямар нэгэн байдлаар дэмжиж эсвэл хуульчлаагүйг нотолж,

Энэ конвенц нь хууль бус худалдаанаас үүдэх асуудлуудыг дангаар шийдвэрлэх шийдэл бус, харин олон улсын соёлын хамтын ажиллагааг бэхжүүлэх үйл явцыг өрнүүлж, улс хоорондын соёлын солилцооны гэрээ хэлэлцээрүүд, хууль ёсны худалдаанд зохих байр суурь эзлэхийг ухамсарлааж,

Техникийн хамтын ажиллагаа, археологийн дурсгалт газрын биет хамгаалалт, бүртгэл ашиглах болон боловсруулах гэх зэрэг соёлын эд зүйлсийг хамгаалах үр дүнтэй бусад арга хэмжээтэй энэ конвенцийн хэрэгжилт хавсрах ёстойг хүлээн зөвшиөөрч,

Олон байгууллагын соёлын үнэт зүйлийг хамгаалах ажил, ялангуяа хууль бус худалдааны тухай ЮНЕСКО-гийн 1970 оны Конвенц болон хувийн салбарын боловсруулсан ёс зүйн дурмуудэд хүндэтгэл үзүүлээд,

Дараахыг тохиролцов:

I БҮЛЭГ - ХЭРЭГЛЭХ ХҮРЭЭ БА ТОДОРХОЙЛОЛТ

1 дүгээр зүйл

Олон улсын шинжтэй нэхэмжлэлд энэ конвенцийг хэрэглэнэ:

- (a) хулгайлсан соёлын эд зүйлсийг эгүүлэх;
- (b) соёлын өвөө хамгаалах зорилгоор соёлын эд зүйлсийн экспортыг зохицуулсан хуулийг нь зөрчин хэлэлцэн тохирогч улсын нутаг дэвсгэрээс гаргасан соёлын эд зүйлсийг (цаашид “хууль бусаар экспортолсон соёлын эд зүйлс” гэх) буцаах.

2 дугаар зүйл

Энэ гэрээний хавсралтын аль нэг ангилалд хамарагдах, шашны эсвэл бус үндэслэлээр археологи, түүхийн өмнөх үе, түүх, утга зохиол, урлаг, шинжлэх ухааны ач холбогдолтой эд зүйлсийг энэ конвенцийн зорилгын дагуу соёлын эд зүйлс гэнэ.

II БҮЛЭГ – ХУЛГАЙЛСАН СОЁЛЫН ЭД ЗҮЙЛСИЙН ЭГҮҮЛЭГ

3 дугаар зүйл

(1) Хулгайлсан соёлын эд зүйлийг эзэмшигч нь эгүүлэн олгох ёстой.

(2) Хууль бусаар малтсан эсвэл хуулийн дагуу малтаад хууль бусаар хадгалсан соёлын эд зүйлийг малтлага хийгдсэн улсын хуульд нийцүүлэн энэ конвенцийн зорилгын дагуу хулгайлсан гэж үзнэ.

(3) Соёлын эд зүйлийн эзэмшигч болон байршлыг нэхэмжлэгч тогтоож, мэдсэн цагаас хойш гурван жил, ер нь аль ч тохиолдолд хулгай гарсан цагаас хойш тавин жилийн дотор аливаа эгүүлэх нэхэмжлэлийг хүргүүлнэ.

(4) Харин аливаа олж тогтоосон хөшөө дурсгал, археологийн дурсгалт газрын салшгүй бүрэлдэхүүн хэсэг эсвэл нийтийн цуглуулгад хамарагдах соёлын эд зүйлийг эгүүлэх нэхэмжлэл хязгаарлах хугацаанд захирагдахгүй бөгөөд гагцхүү соёлын эд зүйлийн эзэмшигч болон байршлыг нэхэмжлэгч тогтоож, мэдсэн цагаас хойш гурван жилийн дотор хүргүүлнэ.

(5) Нэхэмжлэл 75 жилийн хязгаарлах хугацаанд захирагдах эсвэл үүн шиг урт хугацааг өөрийн хуульд зааснаа аливаа хэлэлцэн тохирогч улс өмнөх хэсгийн заалтыг үл харгалзан мэдэгдэж болно. Ийм мэдэгдэл хийсэн хэлэлцэн тохирогч улсад байгаа хөшөө дурсгал, археологийн дурсгалт газар эсвэл нийтийн цуглуулгаас салган авсан соёлын эд зүйлийг эгүүлэх нэхэмжлэл нөгөө хэлэлцэн тохирогч улсад гаргавал мэдэгдсэн хязгаарлах хугацаанд мөн захирагдана.

(6) Гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах эсвэл нэгдэн орох үед өмнөх хэсэгт дурдсан мэдэгдлийг хийнэ.

(7) Энэ конвенцийн зорилгын дагуу “нийтийн цуглуулга” гэдэгт хэсэгчлэн бүртгэн тоолсон эсвэл өөрөөр олж тогтоосон соёлын эд зүйлс, өмч багтана:

- (a) хэлэлцэн тохирогч улсын;
- (b) хэлэлцэн тохирогч улсын бүс нутаг эсвэл орон нутгийн эрх бүхий байгууллагын;
- (c) хэлэлцэн тохирогч улсын шашны байгууллагын; эсвэл
- (d) хэлэлцэн тохирогч улсад соёл, боловсрол, шинжлэх ухааны үндсэн чиг үүрэгтэй байгуулагдаж, нийтийн ашиг сонирхолд үйлчилдэг нь улсдаа хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагын.

(8) Мөн, хэлэлцэн тохирогч улсын овог, уугуул ард иргэдийн бүл хамт олон хэрэглэдэг, тэдэнд хамаарах, чухал ач холбогдол болон тахилга шүтлэгтэй, уламжлалт зан үйлээс нь салгашгүй соёлын эд зүйлийг эгүүлэх нэхэмжлэл нийтийн цуглуулгад хэрэглэх хязгаарлах хугацаанд захирагдана.

4 дүгээр зүйл

(1) Хулгайсан соёлын эд зүйлийг эгүүлэн олгох ёстой эзэмшигч худалдаж аваадаа эд зүйл хулгайллагдсаныг мэдээгүй буюу мэдэх боломжгүй байсан бөгөөд зохих ёсны магадлан хяналт хийснээ нотолж чадвал эд зүйлийг эгүүлэн олгох үед шударга, оновчтой нөхөн төлбөр авах эрхтэй.

(2) Соёлын эд зүйлийг эзэмшигчид шилжүүлсэн эсвэл өмнөх шилжүүлэгч аливаа этгээдээр нөхөн төлбөр төлүүлэх зохих хүчин чармайлтыг өмнөх хэсэгт дурдсан нөхөн төлбөр авах эзэмшигчийн эрхийг хохироохгүйгээр нэхэмжлэл хүргүүлсэн улсын хуульд нийцүүлэн гаргана.

(3) Нэхэмжлэгч, эзэмшигчид нөхөн төлбөр өгөх шаардлага гарвал өөр этгээдээр төлүүлэх нэхэмжлэгчийн эрхийг хохироогүйгээр хийнэ.

(4) Эзэмшигч зохих ёсны магадлан хяналт хийснийг тогтооход худалдаж авсан бүх нөхцөл байдал, тухайлбал талуудын шинж байдал, төлсөн үнэ, эзэмшигч олж мэдэх боломжтой байсан бусад холбогдох мэдээлэл, бичиг баримттай танилцаж, хандаж болох байсан хулгайлсан соёлын эд зүйлсийн бүртгэл болон бусад хүртээмжтэй агентлаг байгууллагаас лавласан зэрэг аливаа хариуцлагатай этгээд тухайн нөхцөл байдалд хэрэгжүүлэх бусад арга хэмжээг авсан эсэхийг харгалзана.

(5) Соёлын эд зүйлийг өвлүүлсэн эсвэл өөрөөр үнэ төлбөргүй шилжүүлсэн этгээдээс эзэмшигч давуу эрх эдлэхгүй.

III БҮЛЭГ – ХУУЛЬ БУСААР ЭКСПОРТОЛСОН СОЁЛЫН ЭД ЗҮЙЛСИЙН БУЦААЛТ

5 дугаар зүйл

(1) Хүсэлт гаргагч улсын нутаг дэвсгэрээс хууль бусаар экспортолсон соёлын эд зүйлийг буцаах шийдвэр гаргахыг өөр хэлэлцэн тохирогч улсын шүүх, бусад эрх бүхий байгууллагаас хэлэлцэн тохирогч улс хүсэж болно.

(2) Соёлын өвөө хамгаалах зорилгоор экспортыг зохицуулсан хуулийнх нь дагуу олгосон зөвшөөрлөөр хүсэлт гаргагч улсын нутаг дэвсгэрээс үзэсгэлэнд гаргах, судалж шинжлэх, сэргээн засварлах гэх зэрэг зориулалтаар түр экспортолсон соёлын эд зүйлийг зөвшөөрлийн нөхцлийн дагуу буцаагаагүй бол хууль бусаар экспортолсон гэж үзэх болно.

(3) Нутаг дэвсгэрээс нь эд зүйлийг гаргахад дараах нэг болон түүнээс олон ашиг сонирхлыг ноцтой хохироосныг хүсэлт гаргагч улс тогтоовол хүлээн авагч улсын шүүх, бусад эрх бүхий байгууллага хууль бусаар экспортолсон соёлын эд зүйлийг буцаах шийдвэр гаргана:

- (a) эд зүйлийн биет хадгалалт эсвэл түүний унаган байдал;
- (b) цогцолбор эд зүйлийн бүрэн бүтэн байдал;
- (c) мэдээллийн хадгалалт, жишээлбэл, шинжлэх ухааны эсвэл түүхийн шинжтэй мэдээлэл;
- (d) овог, уугуул ард иргэдийн бүл хамт олны уламжлалт зан үйлд хэрэглэдэг эд зүйл,

Эсвэл хүсэлт гаргагч улсад соёлын чухал ач холбогдолтойг тогтоосон эд зүйл.

(4) Энэ зүйлийн 1-ээс 3 дахь хэсгүүдэд заасан шаардлагуудыг хангасан эсэхийг хүлээн авагч улсын шүүх, бусад эрх бүхий байгууллага тодорхойлоход дөхөм болох магадлалтай бодит болон хууль зүйн шинж чанартай мэдээллийг энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу гаргасан аливаа хүсэлт агуулж эсвэл хавсаргана.

(5) Соёлын эд зүйлийн эзэмшигч болон байршлыг хүсэлт гаргагч улс тогтоож, мэдсэн цагаас хойш гурван жил, ер нь аль ч тохиолдолд энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан зөвшөөрлийн дагуу эд зүйлийг буцаах ёстой эсвэл экспортолсон огнооноос хойш тавин жилийн дотор аливаа буцаах хүсэлтийг хүргүүлнэ.

6 дугаар зүйл

(1) Соёлын эд зүйлийг хууль бусаар экспортолсны дараа худалдаж авсан эзэмшигч худалдаж авах үедээ эд зүйл хууль бусаар экспортлогдсоныг мэдээгүй буюу мэдэх боломжгүй байсан гэвэл эд зүйлийг буцаан олгох үед хүсэлт гаргагч улсаас шударга, оновчтой нөхөн төлбөр авах эрхтэй.

(2) Худалдаж авсан нөхцөл байдлууд, тухайлбал хүсэлт гаргагч улсын хуулийн дагуу шаардагдах экспортын гэрчилгээ бий эсэх зэргийг харгалзан соёлын эд зүйлийг хууль бусаар экспортолсныг эзэмшигч мэдээгүй буюу мэдэх боломжгүй байсныг тодорхойлно.

(3) Соёлын эд зүйлийг тухайн улсад нь буцаах ёстой эзэмшигч хүсэлт гаргагч улстай тохиролцсоны дагуу нөхөн төлбөрийн оронд дараах шийдвэрийг гаргаж болно:

- (a) эд зүйлийн өмчлөх эрхийг хадгалах; эсвэл
- (b) хүсэлт гаргагч улсад оршин сууж шаардагдах баталгаа гаргаж өгөх сонгосон этгээддээ төлбөртэй эсвэл төлбөргүй өмчлөх эрхийг шилжүүлэх.

(4) Энэ зүйлийн дагуу соёлын эд зүйлийг буцаах зардлыг өөр этгээдээр төлүүлэх эрхээ хохироохгүйгээр хүсэлт гаргагч улс даана.

(5) Соёлын эд зүйлийг өвлүүлсэн эсвэл өөрөөр үнэ төлбөргүй шилжүүлсэн этгээдээс эзэмшигч давуу эрх эдлэхгүй.

7 дугаар зүйл

(1) Энэ бүлгийн заалтуудыг доорх тохиолдолд хэрэглэхгүй:

- (a) буцаах хүсэлт гаргах үед тухайн соёлын эд зүйлийн экспорт хууль бус байхаа больсон; эсвэл
- (b) бүтээгч нь амьд сэруүн эсвэл түүнийг нас барсны дараах 50 жилийн дотор эд зүйлийг экспортолсон.

(2) Овог, уугуул ард иргэдийн бүл хамт олны нэг болон олон гишүүн бүтээж уламжлалт зан үйлдээ хэрэглэдэг соёлын эд зүйлд, өмнөх хэсгийн (b) дэд хэсгийн заалтыг үл харгалзан, энэ бүлгийн заалтуудыг хэрэглэх хийгээд тухайн бүл хамт олонд эд зүйлийг буцаана.

IV БҮЛЭГ – ЕРӨНХИЙ ЗААЛТУУД

8 дугаар зүйл

(1) II бүлэгт заасан нэхэмжлэл, III бүлэгт заасан хүсэлтийг соёлын эд зүйл байгаа хэлэлцэн тохирогч улсын шүүх, бусад эрх бүхий байгууллагад гаргахаас гадна хэлэлцэн тохирогч улсуудад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хэм хэмжээний дагуу шүүн таслах бүрэн эрхтэй шүүх, бусад эрх бүхий байгууллагад хүргүүлж болно.

(2) Талууд маргаанаа аль ч шүүх, бусад эрх бүхий байгууллага эсвэл арбитрт хүргүүлэхийг тохирч болно.

(3) Эд зүйл байгаа хэлэлцэн тохирогч улсын хуулийн дагуу боломжтой түр зуурын, тухайлбал хамгаалалтын арга хэмжээг өөр хэлэлцэн тохирогч улсын шүүх, бусад эрх бүхий байгууллагад эгүүлэх нэхэмжлэл эсвэл буцаах хүсэлт хүргүүлсэн тохиолдолд ч авч болно.

9 дүгээр зүйл

(1) Хулгайлсан эсвэл хууль бусаар экспортолсон соёлын эд зүйлсийг эгүүлэх, буцаахад энэ конвенцид зааснаас давуу аливаа хэм хэмжээг хэлэлцэн тохирогч улс хэрэгжүүлэхэд тус конвенц огт саад болохгүй.

(2) Энэ конвенцийн заалтуудаас ангид, өөр хэлэлцэн тохирогч улсын шүүх, бусад эрх бүхий байгууллагын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, хэрэгжүүлэх үүрэг бий болгох мэтээр энэ зүйлийг тайлбарлахгүй.

10 дугаар зүйл

(1) Нэхэмжлэл хүргүүлсэн улсад энэ конвенц хүчин төгөлдөр болсны дараа хулгайлсан соёлын эд зүйлд зөвхөн хамаатай II бүлгийн заалтууд доорх нөхцөлд хэрэгжинэ:

- (a) хэлэлцэн тохирогч улсын нутаг дэвсгэрээс, тухайн улсад энэ конвенц хүчин төгөлдөр болсны дараа эд зүйлийг хулгайлсан бол; эсвэл
- (b) хэлэлцэн тохирогч улсад энэ конвенц хүчин төгөлдөр болсны дараа тухайн улсад эд зүйл байгаа.

(2) Хүсэлт гаргагч болон хүргүүлсэн улсуудад энэ конвенц хүчин төгөлдөр болсны дараа хууль бусаар экспортолсон соёлын эд зүйлд зөвхөн хамаатай III бүлгийн заалтууд хэрэгжинэ.

(3) Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заагаагүй эсвэл конвенц хүчин төгөлдөр болохоос өмнө үйлдсэн аливаа хууль бус шинжтэй хэлцлийг энэ конвенц ямар нэгэн байдлаар хуульчлаагүй хийгээд конвенц хүчин төгөлдөр болохоос өмнө хулгайлсан эсвэл хууль бусаар экспортолсон соёлын эд зүйлийг эгүүлэх, буцаахад энэ конвенцийн хүрээнээс гадна хэрэгжүүлэх боломжтой эрх зүйн хамгаалалтын хэрэглүүрийн дагуу аливаа улс эсвэл бусад этгээд нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарлахгүй.

V БҮЛЭГ – ТӨГСГӨЛИЙН ЗААЛТУУД

11 дүгээр зүйл

(1) Хулгайлсан эсвэл хууль бусаар экспортолсон соёлын эд зүйлсийн олон улсын буцаалтын тухай ЮНИДРУА-гийн Конвенцийн төсөл батлах Дипломат бага хурлын хаалтын хуралдаанд конвенцид гарын үсэг зурах нээлттэй бөгөөд Ром хотноо 1996 оны 6 дугаар сарын 30 хүртэл бүх улс гарын үсэг зурж болно.

(2) Энэ конвенцид гарын үсэг зурсан улсууд түүнийг соёрхон баталж, хүлээн зөвшөөрч эсвэл батална.

(3) Гарын үсэг зурах нээлттэй болсон огнооноос хойш гарын үсэг зураагүй улсууд нэгдэн ороход энэ конвенц нээлттэй.

(4) Соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах эсвэл нэгдэн ороход шаардах албан ёсны батламж жуух бичиг эсвэл баримт бичгийг хадгалагчид хадгалуулна.

12 дугаар зүйл

(1) Соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан эсвэл нэгдэн орсон тав дахь батламж жуух бичиг эсвэл баримт бичгийг хадгалуулсан огнооноос хойш зургаан сарын эхний өдөр энэ конвенц хүчин төгөлдөр болно.

(2) Соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан эсвэл нэгдэн орсон тав дахь батламж жуух бичиг эсвэл баримт бичгийг хадгалуулсны дараа энэ конвенцийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах эсвэл нэгдэн орох улс бүрийн хувьд соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан эсвэл нэгдэн орсон батламж жуух бичиг эсвэл баримт бичгийг хадгалуулсан огнооноос хойш зургаан сарын эхний өдөр энэ конвенц хүчин төгөлдөр болно.

13 дугаар зүйл

(1) Аливаа хэлэлцэн тохирогч улс хууль зүйн үүрэг хүлээсэн, энэ конвенцийн зохицуулж буй асуудлуудыг хамарсан заалтууттай олон улсын баримт бичгийг хэрэв тухайн улс ийм баримт бичгээр хүлээсэн үүргийнхээ дагуу эсрэг мэдэгдэл хийгээгүй бол энэ конвенц хөндөхгүй.

(2) Аливаа хэлэлцэн тохирогч улс нэг болон түүнээс олон хэлэлцэн тохирогч улстай хоорондын харилцаандаа энэ конвенцийн хэрэгжилтийг сайжруулах үүднээс гэрээ хэлэлцээрүүд байгуулж болно. Ийм гэрээ хэлэлцээр байгуулсан улсууд нэг хувийг хадгалагчид шилжүүлэх ёстой.

(3) Бүс нутаг эсвэл эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн хэлэлцэн тохирогч улсууд тухайн байгууллагын дотоод дүрмийг улс хоорондын харилцаандаа мөрдөх тул хэрэглэх хүрээ давхцсан энэ конвенцийн заалтуудыг тухайн улсууд хоорондын харилцаандаа мөрдөхгүй гэж мэдэгдэж болно.

14 дүгээр зүйл

(1) Хэрэв хэлэлцэн тохирогч улс хоёр болон түүнээс олон нутаг дэвсгэрийн нэгжтэй бол, тэдгээрт энэ конвенцид холбогдох асуудлаар ялгаатай эрх зүйн тогтолцоо хэрэгждэг эсэхээс үл шалтгаалан гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах эсвэл нэгдэн орох үедээ энэ конвенц нутаг дэвсгэрийнх нь бүх нэгж эсвэл нэг, түүнээс олон нэгжид үйлчлэхийг мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлээ хэдийд ч өөр мэдэгдлээр сольж болно.

(2) Эдгээр мэдэгдлүүдийг өргөдлөөр хадгалагчид мэдэгдэхдээ энэ конвенц үйлчлэх нутаг дэвсгэрийн нэгжүүдийг тодорхой заана.

(3) Хэрэв энэ зүйлийн дагуу хийсэн мэдэгдлийн үр дүнд энэ конвенц хэлэлцэн тохирогч улсын нутаг дэвсгэрийн бүх нэгжийг бус харин нэг, түүнээс олон нэгжид үйлчлэх бол доорх байдлаар ойлгоно:

- (a) 1 дүгээр зүйлд заасан хэлэлцэн тохирогч улсын нутаг дэвсгэр гэдгийг тухайн улсын нутаг дэвсгэрийн нэгжийн газар нутаг;
- (b) хэлэлцэн тохирогч эсвэл хүлээн авагч улсын шүүх, бусад эрх бүхий байгууллага гэдгийг тухайн улсын нутаг дэвсгэрийн нэгжийн шүүх, бусад эрх бүхий байгууллага;
- (c) 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан соёлын эд зүйл байгаа хэлэлцэн тохирогч улс гэдгийг эд зүйл байгаа тухайн улсын нутаг дэвсгэрийн нэгж;
- (d) 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан эд зүйл байгаа хэлэлцэн тохирогч улсын хууль гэдгийг эд зүйл байгаа тухайн улсын нутаг дэвсгэрийн нэгжийн хууль; мөн

(e) 9 дүгээр зүйлд заасан хэлэлцэн тохирогч улс гэдгийг тухайн улсын нутаг дэвсгэрийн нэгж.

(4) Хэрэв хэлэлцэн тохирогч улс энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу мэдэгдэл хийхгүй бол энэ конвенц тухайн улсын нутаг дэвсгэрийн бүх нэгжид үйлчилнэ.

15 дугаар зүйл

(1) Энэ конвенцид гарын үсэг зурах үед хийсэн мэдэгдлүүдийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх эсвэл батлахдаа нотолно.

(2) Мэдэгдлүүд болон тэдгээрийн нотолгоог бичгээр үйлдэж, албан ёсны өргөдлөөр хадгалагчид мэдэгдэнэ.

(3) Энэ конвенц тухайн улсад хүчин төгөлдөр болохтой зэрэгцэн мэдэгдлийг дагаж мөрдөнө. Харин ийнхүү хүчин төгөлдөр болсноос хойш албан ёсны өргөдлөөр хадгалагч хүлээн авсан мэдэгдлийг хадгалуулсан огнооноос хойш зургаан сарын эхний өдрөөс дагаж мөрдөнө.

(4) Энэ конвенцийн дагуу мэдэгдэл хийсэн аливаа улс хадгалагчид хандаж бичгээр үйлдсэн, албан ёсны өргөдлөөр хэдийд ч мэдэгдлээ эгүүлэн авч болно. Өргөдөл хадгалсан огнооноос хойш зургаан сарын эхний өдрөөс ийм эгүүлэн авалтыг дагаж мөрдөнө.

16 дугаар зүйл

(1) Аливаа улс 8 дугаар зүйлийн дагуу соёлын эд зүйлсийг эгүүлэх нэхэмжлэл, буцаах хүсэлт хүргүүлэхдээ дараах нэг болон түүнээс олон журмаар гаргаж болохыг хэлэлцэн тохирогч улс бүр энэ конвенцид гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах эсвэл нэгдэн орохдоо мэдэгдэнэ:

- (a) мэдэгдэл хийсэн улсын шүүх, бусад эрх бүхий байгууллагад шууд;
- (b) нэхэмжлэл, хүсэлт хүлээн авч шүүх, бусад эрх бүхий байгууллагад дамжуулах чиг үүрэгтэйгээр тухайн улс томилсон нэг эсвэл олон байгууллагад;
- (c) дипломат эсвэл консулын шугамаар хүргүүлнэ.

(2) II, III бүлгийн заалтуудад заасан эгүүлэх эсвэл буцаах шийдвэр гаргах шүүх, бусад эрх бүхий байгууллагыг хэлэлцэн тохирогч улс бүр мөн томилж болно.

(3) Энэ зүйлийн 1 ба 2 дахь хэсгийн дагуу хийсэн мэдэгдлүүдийг хэдийд ч шинэ мэдэгдлээр өөрчилж болно.

(4) Хэлэлцэн тохирогч улсуудын хооронд байгуулсан байж болох иргэний болон худалдааны асуудлаар шүүхийн туслалцаа үзүүлэх хоёр болон олон талт гэрээ хэлэлцээрүүдийг энэ зүйлийн 1-ээс 3 дахь хэсгийн заалтууд хөндөхгүй.

17 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч улс бүр соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан эсвэл нэгдэн орсон батламж жуух бичиг эсвэл баримт бичгээ хадгалуулсан огнооноос хойш зургаан сараас хэтрэлгүй конвенцийн албан ёсны аль нэгэн хэлээр соёлын эд зүйлсийн экспортыг зохицуулсан хууль тогтоомжийнхаа талаар бичгээр үйлдсэн мэдээллийг хадгалагчид хүргүүлнэ. Мэдээллийг тухай бүр зохих ёсоор шинэчилнэ.

18 дугаар зүйл

Энэ конвенцид тодорхой тусгаснаас өөр тайлбар хийхийг зөвшөөрөхгүй.

19 дүгээр зүйл

(1) Энэ конвенц тухайн улсад хүчин төгөлдөр болсон огнооноос хойш аливаа оролцогч улс шаардагдах баримт бичгийг хадгалагчид хадгалуулснаар хэдийд ч цуцалж болно.

(2) Цуцлах баримт бичгийг хадгалагчид хадгалуулсны дараах зургаан сарын эхний өдрөөс цуцлалтыг дагаж мөрдөнө. Цуцлах баримт бичигт даган мөрдөж эхлэх хугацааг уртсгахаар заасан нөхцөлд хадгалагчид хадгалуулснаас хойш тийнхүү заасан урт хугацаа дуусахад цуцлалтыг дагаж мөрдөнө.

(3) Цуцлалтыг дагаж мөрдөх огнооноос өмнө соёлын эд зүйлийг эгүүлэх нэхэмжлэл, буцаах хүсэлт гаргасан бол дээрх цуцлалтыг үл харгалзан энэ конвенц хэрэгжинэ.

20 дугаар зүйл

Хувийн эрх зүйг нэгтгэх олон улсын хүрээлэнгийн (ЮНИДРУА) Ерөнхийлөгч энэ конвенцийн бодит үйл ажиллагааг дүгнэх тусгай хороог тогтмол хугацаанд эсвэл таван хэлэлцэн тохирогч улсын хүсэлтээр хэдийд ч зарлан хуралдуулж болно.

21 дүгээр зүйл

(1) Бүгд Найрамдах Итали Улсын Засгийн газар энэ конвенцийг хадгална.

(2) Бүгд Найрамдах Итали Улсын Засгийн газар:

(a) Энэ конвенцид гарын үсэг зурсан эсвэл нэгдэн орсон бүх улс болон Хувийн эрх зүйг нэгтгэх олон улсын хүрээлэнгийн (ЮНИДРУА) Ерөнхийлөгчид мэдээлнэ:

(i) шинээр гарын үсэг зурсан эсвэл соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан эсвэл нэгдэн орсон баримт бичиг бүрийг хадгалуулсан огноотой хамт;

- (ii) энэ конвенцийн дагуу хийсэн мэдэгдэл бүрийг;
 - (iii) аливаа мэдэгдлийн эгүүлэн авалт бүрийг;
 - (iv) энэ конвенц хүчин төгөлдөр болох огноо;
 - (v) 13 дугаар зүйлд заасан гэрээ хэлэлцээрүүдийг;
 - (vi) энэ конвенцийг цуцлах баримт бичгийн хадгалалт хийгээд хадгалуулсан огноог дагаж мөрдөх огноотой хамт;
- (b) энэ конвенцид гарын үсэг зурсан, нэгдэн орсон бүх улс болон Хувийн эрх зүйг нэгтгэх олон улсын хүрээлэнгийн (ЮНИДРУА) Ерөнхийлөгчид энэ конвенцийн баталгаат үнэн хуулбаруудыг дамжуулна;
- (c) хадгалагч наарт оногддог бусад үүргийг гүйцэтгэнэ.

Зохих эрх, бүрэн эрхийн итгэмжлэл олгогдсон бүрэн эрхт төлөөлөгчид энэ конвенцид гарын үсэг зуран гэрчлэв.

Мянга есөн зуун ерэн таван оны зургадугаар сарын хорин дөрөвний өдөр Ром хотноо хоёр жинхэлсэн эх бичвэр нь адил хүчинтэй англи, франц хэлээр нэг эх хувийг үйлдэв.

ХАВСРАЛТ

- (a) Палеонтологийн ач холбогдолтой эд зүйлс болон ургамал, амьтад, эрдэс, анатомийн ховор цуглуулга, дээж;
- (b) улс үндэстний хувьд чухал үйл явдал, үндэсний удирдагчид, сэтгэгчид, эрдэмтэд, жүжигчдийн амьдрал болон шинжлэх ухаан, техник технологи, цэрэг, нийгмийн түүх зэрэг түүхтэй холбоотой үнэт зүйл;
- (c) ил болон нууцаар малтсан археологийн малтлагын бүтээгдэхүүн эсвэл археологийн нээлтүүд;
- (d) уран сайхан, түүхийн хөшөө дурсгал эсвэл археологийн дурсгалт газраас салгасан бүрэлдэхүүн хэсэг;
- (e) сийлсэн тамга, зоос, бичээс гэх зэрэг зуун жилээс илүү настай эртний эдлэл;
- (f) угсаатны зүйн ач холбогдолтой эд зүйлс;
- (g) уран сайхны ач холбогдолтой үнэт зүйл, тухайлбал:
 - (i) аливаа эд материал, суурин дээр гараар бүгдийг бүтээсэн зураг, уран зураг, хар зураг (гараар чимэглэсэн аж үйлдвэрийн бүтээгдэхүүнүүд болон үйлдвэрийн загварууд үл хамаарна);
 - (ii) аливаа эд материалаар бүтээсэн уран барилга болон уран баримлын урлагийн бүтээлүүдийн эх хувь;
 - (iii) сийлбэр, дардас, чулуун барын эх хувь;
 - (iv) аливаа эд материалаар бүтээсэн уран сайхны сонгомж, эвлүүлгийн эх хувь;
- (h) дангаар эсвэл цуглуулгаар ховор гар бичмэл болон инкунабула, хуучны ном, баримт бичиг болон тусгай ашиг сонирхолд хамаарах хэвлэлүүд (түүх, шинжлэх ухаан, утга зохиолын гэх мэт);
 - (i) дангаар эсвэл цуглуулгаар шуудан, татварын болон төсөөтэй маркууд;
 - (j) архивууд, тухайлбал, кино, гэрэл зураг, дуу авианы баримтын архив;
 - (k) зуун жилээс илүү настай гэрийн тавилгын эд өлгийн зүйлс болон хуучны хөгжмийн зэмсгүүд.

**Соёлын эд зүйлсийн
Эгүүлэг ба Буцаалт:
ЮНИДРУА-гийн Конвенц**

**Restitution and Return
of Cultural objects:
UNIDROIT CONVENTION**

MONGOLIAN'S PERSPECTIVE

ННА-71
ДАА-306
Э-739

© Kh.Erdembileg. Зохиогчийн эрхийг хуулиар хамгаалсан. Зохиогчийн зөвшөөрөлгүй хуулбарлах, дахин хэвлэх, хэсэгчлэн ашиглахыг хориглоно.
ebi21@hotmail.com

Зохиогч, орчуулагч (*Author and translator*): Х.Эрдэмбилэг

Ерөнхий редакторууд (*Chief-In-Editors*): Соёлын гавьяат зүтгэлтэн доктор, профессор Н.Уртнасан

СУИС-ийн Соёлын сургуулийн захирал, доктор Г.Сүхбат

Дэд редакторууд (*Assistance Editors*): Хууль сахиулах их сургуулийн Цагдаагийн сургуулийн багш, доктрант Ч.Доржсүрэн

Соёлын өвийн төвийн мэргэжилтэн Ш.Энхтуяа

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч С.Энхтөрөл

СУИС-ийн Соёлын сургуулийн Соёл судлалын тэнхимийн эрхлэгч Ж.Мяндас

Зөвлөх (*Advisor*) Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн захирал, доктор (LL.D) Ц.Мандах

Хэвлэлийн дизайнер: Л.Эрдэнэсувд

Хэвлэлийн хуудас: 14.5 хх

ISBN: 978-99978-961-2-4

СУИС-ийн Соёлын сургуулийн Соёл судлалын тэнхимийн захиалгаар “Соёлын өвийн аюулгүй байдал” ТББ бэлдсэн энэ номонд албан ёсны байр суурийг илэрхийлээгүй тул алдаа мадгийг зөвхөн зохиогч хариуцна.

ГАФ

ЮН

ӨМН

Ном

Зөвл

Тан

I. Ю

II. Е

III.

IV.

V.

Ө

Х